



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 437

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.9, 8.10.11, заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Монголын Хөрөнгийн Бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Оюутан дадлагажуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. Оюутан дадлагажуулах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2003 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.
3. “Монголын Хөрөнгийн Бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Оюутан дадлагажуулах журам”-ыг нийт ажилтнуудад танилцуулах ажлыг зохион байгуулах, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргаа аж ахуйн алба /Ж.Нарантуяа/-нд үүрэг болгосугай.
4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хэрэг эрхлэх газар /Х.Эрдэнэбүрэн/-т даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 сарын
09 өдрийн 437 дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ЫН ОЮУТАН ДАДЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д /цаашид “Бирж” гэх / Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль болон гадаадын их дээд сургуульд эдийн засаг, бизнес, хууль, эрх зүйн чиглэлээр суралцдаг оюутныг дадлагажуулах журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь тус компанид тодорхой шаардлага хангасан оюутнуудыг тодорхой хугацаагаар дадлагажуулах, хөрөнгийн зах зээлийн, судалгаа хийх замаар онолын мэдлэгийг практиктай хослуулан ажлын байрны дадлага туршлагатай болгох, мэдээ мэдээллээр хангаж чадавхжуулах, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2. Энэхүү журам нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Захиргаа хариуцсан нэгж, дадлага удирдаж буй нэгж болон дадлагажигч оюутанд хамаарна.

ХОЁР: Дадлагажигч оюутанд тавигдах шаардлага

- 2.1. Биржид дадлагажигч оюутан дараах шаардлагын хангасан байна. Үүнд:
- 2.1.1 Монгол Улсын маргадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиуд болон Гадаадын их, дээд сургуульд бизнес эдийн засаг, хууль, эрх зүйн, техник технологийн чиглэлээр суралцдаг байх.
 - 2.1.2 Дадлагажигч оюутны сүүлийн 2 улирлын дүнгийн голч нь 3 болон түүнээс дээш байх.
 - 2.1.3 Дадлагажигч оюутан нь 3 болон төгсөх курс байх.

ГУРАВ: Дадлагажигч оюутны бүрдүүлэх материал

- 3.1. Энэхүү журмын 2.1-т заасан шаардлагыг хангасан оюутан доорх материалуудыг бүрдүүлэн, Захиргаа хариуцсан нэгжийн хүний нөөцийн мэргэжилтэнд ирүүлнэ. Үүнд:
- 3.1.1 Анкет;
 - 3.1.2 Их, дээд сургуулийн дадлагын удирдамж;
 - 3.1.3 Их, дээд сургуулийн дадлага хийлгэх тухай хүсэлт бүхий албан бичиг;
 - 3.1.4 Их, дээд сургуулийн сургалтын албанаас өгсөн сүүлийн 2 улирлын дүнгийн баталгаажуулсан жагсаалт;
 - 3.1.5 Цахим үнэмлэхний хуулбар;
 - 3.1.6 Дадлага хийхийг хүссэн өргөдөл;
 - 3.1.7 Дадлага ажлын төлөвлөгөө.

- 3.2. Хүний нөөцийн мэргэжилтэн дадлагажигч оюутны материалыг хүлээн авч, дадлагыг удирдах боломжит ажилтантай тохиролцсны үндсэн дээр оюутныг хуваарилна.

ДӨРӨВ. Дадлагын төрөл, хугацаа

- 4.1. Дадлага нь дадлагажигч оюутны удирдамжаас хамаарч доорх төрөлтэй байна.
- 4.1.1 Танилцах дадлага
 - 4.1.2 Үйлдвэрийн дадлага
- 4.2. Танилцах дадлагын хугацаа нь 14 хоног байна.
- 4.3. Үйлдвэрийн дадлага хийх хугацаа нь 45 хоногоос дээшгүй байна.
- 4.4. Дадлагын цагийн хуваарь 9:00-16:00 цаг байх бөгөөд дадлагажигч оюутан хичээлийн хуваарьт нийцүүлэн дадлагын цагийн хуваарийг Захиргаа хариуцсан нэгжтэй тохиролцсны үндсэн дээр өөрөөр тогтоож болно.

ТАВ. Дадлага удирдагчийн эрх, үүрэг

- 5.1. Дадлагын удирдагч нь Биржийн ажилтан байна. Тэрээр дадлагын оюутантай хамтран ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлд үнэлгээ өгч тайланг Захиргаа хариуцсан нэгжид ирүүлнэ.
- 5.2. Захиргаа хариуцсан нэгж нь дадлагажигч оюутантай нууцын гэрээг байгуулна.
- 5.3. Дадлагын оюутанд тус байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, Биржийн дотоод үйл ажиллагааны дүрэм, журмыг танилцуулж чиглэл өгөх, сургуулиас баталсан дадлагын удирдамжийн дагуу дадлагыг удирдаж зохион байгуулна.
- 5.4. Дадлагажигч оюутныг дадлага хийх хугацаанд дадлага удирдагч холбоотой мэдээллээр хангаж, түүнд дэмжлэг үзүүлэх.
- 5.5. Дадлагажигч оюутан Биржийн Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, оюутныг дадлагажуулах журмыг зөрчсөн тохиолдолд Захиргаа хариуцсан нэгжид холбогдох нотлох баримтыг хавсарган мэдэгдэх.
- 5.6. Дадлагажигч оюутанд дадлагын үр дүнд тодорхойлолт, явцын үнэлгээг өгөх.
- 5.6. Дадлага удирдагч нь дадлагын хугацаанд зохих журмаар оюутанг дадлагажуулах.

ЗУРГАА. Дадлагажигч оюутны эрх, үүрэг

- 6.1. Дадлагажигч оюутан нь сургуулиасаа олгосон удирдамжын дагуу дадлага ажлыг хийж гүйцэтгэх, дадлага удирдагчаас удирдамжинд заасан мэдээллийг авах.
- 6.2. Оюутан нь өөрийн хийж гүйцэтгэсэн дадлага ажлыг үнэн шударгаар үнэлүүлэх.
- 6.3. Дадлагажигч оюутан нь Биржийн хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрмийг мөрдөх.
- 6.4. Дадлагажигч оюутан байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, хэлбэр, зохицуулалттай танилцах, дүн шинжилгээ хийх.
- 6.5. Дадлагажигч оюутан холбогдох хууль, дүрэм, журамтай танилцах, хэрэгцээтэй бол архивын материалтай уншиж, танилцаж болно.
- 6.6. Биржийн тайлан болон бусад мэдээлэлтэй танилцаж, судалгаа хийх.
- 6.7. Биржийн Захиргаа хариуцсан нэгжээс даалгасан цаг үеийн шинжтэй ажлыг тухай бүр хийж гүйцэтгэх.

- 6.8. Дадлагажигч оюутан нь Биржид дадлага хийх хугацаандаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, аливаа мэдээллийг тараахгүй байх.
- 6.9. Дадлагажигч оюутан нь Биржид дадлага хийх хугацаанд ашиглаж буй эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, зориулалтын дагуу гамтай эдэлж, хэрэглэх.
- 6.10. Дадлагажигч оюутан нь дадлагажих хугацаандаа Биржээс явуулдаг Хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалтанд хамрагдаж болно.
- 6.11. Дадлагажигч оюутан дадлагажих хугацаа дуусмагц дадлагын тайлангаа дадлага удирдсан ажилтанд хянуулах бөгөөд захиргаа хариуцсан нэгжид хүргүүлнэ.
- 6.12. Оюутан дадлагажих хугацаандаа бусдад саад болохгүй чимээ шуугиан гаргахгүй бусдыгаа хүндэтгэх.

ДОЛОО. Дадлагажигч оюутан, дадлага удирдагчид хориглох зүйлс

- 7.1. Дадлагажигч оюутан Биржид дадлага хийх хугацаанд доорх зүйлийг хориглоно.
 - 7.1.1 Дадлага удирдагчийн зөвшөөрөлгүйгээр компанийн нууцад хамаарагдах баримт бичгийг хувилах, хэвлэн авах, бусдад дамжуулах, гадагш авч явах;
 - 7.1.2 Ажилтнуудын ажиллах нөхцөлд саад учруулах;
 - 7.1.3 Дадлагажигч оюутан ажилтантай ажлын байран дээр хувийн харилцаа тогтоох
 - 7.1.4 Биржийг төлөөлж аливаа уулзалтад оролцох;
 - 7.1.5 Компанийн эд хөрөнгө, ажилтны эд юмсыг зөвшөөрөлгүй авах.
 - 7.1.6 Дадлагажигч оюутан ажлын байранд гадны хүн оруулах;
 - 7.1.7 Дадлагажигч оюутан нь гаднаас техник тоног төхөөрөмж, эд зүйлсийг харуул хамгаалалтын ажилтанд бүртгүүлэлгүй оруулах.
- 7.2. Дадлага удирдагч дадлагажуулах хугацаанд дараах зүйлийг хориглоно.
 - 7.2.1 Дадлагажигч оюутнаар хувийн шинжтэй ажил хийлгэх;
 - 7.2.2 Дадлагын удирдамж, төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил хийлгэх;
 - 7.2.3 Дадлагажигч оюутныг ажлын бус цаг, өдрөөр ажиллуулах;
 - 7.2.4 Дадлагажигч оюутантай ажлын байран дээр хувийн харилцаа тогтоох;
 - 7.2.5 Дадлагажигч оюутанд аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх;
 - 7.2.6 Дадлагажигч оюутнаас аливаа хэлбэрээр үнэ бүхий зүйл авах.

НАЙМ. Хариуцлага

- 8.1. Дадлагажигч оюутан нь МХБ "ТӨХК"-ийн Нууцын журам, Хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн дүрэм, оюутныг дадлагажуулах журмыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд Захиргаа хариуцсан нэгжээс дадлагыг зогсоож холбогдох арга хэмжээг авна.
- 8.2. Дадлага удирдагчийн зүгээс дадлагажигч нь биржийн дүрэм, журмыг зөрчсөн гэж үзвэл Захиргаа хариуцсан нэгж хүсэлтийг хүлээн авч хянаж үзээд шийдвэрлэнэ.
- 8.3. Дадлагажигч оюутан нь уг журмын дагуу дадлагын ажлаа хийгээгүй тохиолдолд удирдагч ажилтны зүгээс харъяалагдах их, дээд сургуулийн захиргаанд мэдэгдэж, дадлага хийлгэхээс татгалзана.
- 8.4. Энэ журмын зөрчсөн оюутанд дадлагын тодорхойлолт, үнэлгээ өгөхгүй болно.
- 8.5. Дадлага удирдагч дадлагыг зохих журмаар удирдаагүй үйлдэл, эс үйлдэл нь дадлагажигч оюутны дадлагын явц, үр дүнд бодитойгоор нөлөөлсөн бол дадлага удирдагчид Захиргаа хариуцсан нэгжид хариуцлага ногдуулна.